



**МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН
ҮНДЭСНИЙ ПАРКЫН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

ИнтраПарк

2020 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 11-66

Улаанбаатар хот

**Интрапренёршипийн үйл ажиллагааны
журам батлах тухай,**

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.11 дэх заалтууд, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 194-р тогтоол, “Мэдээлэл технологийн үндэсний паркийн” дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Мэдээлэл технологийн үндэсний парк” ТӨААТҮГ-н Интрапренёршипийн үйл ажиллагааны журмыг хавсралтаар баталсугай.
2. Интрапренёршипийн үйл ажиллагааны журмыг 2020 оны 12 дугаар сарын 18-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төслийн удирдлага, хамтын ажиллагааны хэлтсийн дарга /П.Наранцэцэг/-д үүрэг болгосугай.



ЗАХИРАЛ *[Signature]* Э.ЦОГТГЭРЭЛ

“Мэдээлэл, технологийн үндэсний парк”-ын
Захирлын 2020 оны 1-дүгээр сарын 1-ний өдрийн
11-66 тоот тушаалын хавсралт



Интрапренёршипийн үйл ажиллагааны журам

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. МТҮП-н ажилтнуудын энтерпренёр сэтгэлгээг хөгжүүлж, шинэлэг санааг дэмжих зорилгоор интрапренёрийг зах зээлд гаргахад дэмжлэг үзүүлэх харилцааг зохицуулахад энэхүү журмыг баримтална.
- 1.2. Интрапренёршип журмын зорилго нь шинэ дэвшилтэт санааг бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хөгжүүлэхэд дэмжлэг туслалцаа шаардлагатай төслийг санхүүгийн болон үйл ажиллагааны хувьд тогтвортой болгон дотоод, гадаадын зах зээлд өрсөлдөх чадвартай иргэн, баг, ААН болгон өсгөн бойжуулахад оршино.
- 1.3. Төсөл нь мэдээллийн технологид суурилсан салбар болон салбар дундын бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.
- 1.4. Энэхүү журмын 2 дугаар зүйлд заасан болзлыг хангаж хэлэлцүүлэгт оролцсон ажилчдын 80-с дээш хувийн үнэлгээ авсан ажилтныг МТҮП-ын интрапренёр болсон гэж үзнэ.
- 1.5. МТҮП-ын интрапренёрт дэмжлэг үзүүлэх хугацаа нь хагас жил байна.
- 1.6. МТҮП-с интрапренёрийн төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хугацаа 1 жил байна.
- 1.7. Интрапренёршипийн хөтөлбөрт жилд 1 төслийг хамруулж болно.
- 1.8. Интрапренёрийг дэмжихдээ хэрэгжих бололцоо бүхий төслийг шалгаруулахдаа нээлттэй өрсөлдөөний зарчмыг баримтална.
- 1.9. Энэхүү журам нь МТҮП-ын холбогдох дүрэм, журам, гэрээний салшгүй хэсэг байна.
- 1.10. Нэр томъёоны тайлбар:
 - **Интрапренёр** гэдэг нь байгууллага дотор бүтээлч санаа, төслийг хөгжүүлж, хэрэгжүүлж байгаа ажилтан, албан хаагч
 - **Интрапренёршип** гэдэг нь байгууллагын үр дүн, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд компани дотор шинээр бизнес бий болгох үйл явц
 - **Интрапренёршип хөтөлбөр** гэдэг нь интрапренёр болон төслийн багийн зорилго, зорилтыг хангахад чиглэсэн өөр хоорондоо уялдаа бүхий багц

ХОЁР. ТАВИГДАХ ШААРДЛАГА, БОЛЗОЛ НӨХЦӨЛ

- 2.1. Төсөл нь дараах шаардлагуудыг хангасан байна.
 - 2.1.1 Шинэлэг байх;
 - 2.1.2 Шийдэл гаргасан байх;
 - 2.1.3 Үр ашгийг тодорхойлсон байх;
 - 2.1.4 Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байх;
 - 2.1.5 Нийгэм, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэсэн байх;
- 2.2. Хамт олноор хэлэлцүүлсэн байх;
 - 2.2.1 Нийт ажилчдын 60-аас дээш хувийн ирцтэй байх;
 - 2.2.2 10-15 минутын танилцуулга бэлтгэх;
 - 2.2.3 Хэлэлцүүлэгт оролцсон ажилчдын 80-аас дээш хувийн дэмжлэг авсан байх;

- 2.3. Интрапренёр нь дараах болзол, нөхцлүүдийг хүлээн зөвшөөрсөн байна. Үүнд:
- 2.3.1 МТҮП-д 2 ба түүнээс дээш жил ажиллаж байгаа ажилтан байх;
 - 2.3.2 Төслийн шаардлагыг хангасан санааг хянах, үнэлэх, дэмжих үйл ажиллагааг хүлээн зөвшөөрсөн байх;
 - 2.3.3 Интрапренёр нь 3.2 заалтыг хүлээн зөвшөөрсөн байх;
 - 2.3.4 Бүтээгдэхүүн, үйлчилгээ олны хүртээл болсон тохиолдолд МТҮП-ын нэрийг дурьдаж байх;
 - 2.3.5 Хэрвээ бие даан үйл ажиллагаа явуулахаар хүсэлт гаргавал хөдөлмөрийн гэрээг өөрийн хүсэлтээр дуусгавар болгохыг зөвшөөрсөн өргөдөл гаргах; (энэхүү заалт нь 3.2.1.2-т хамаарна)

ГУРАВ. ДЭМЖЛЭГ

- 3.1. Интрапренёрт дараах дэмжлэгийг үзүүлнэ
- 3.1.1 Интрапренёр нь хүний нөөцийг бүрдүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд нэмэлт багийг бүрдүүлж өгч болно.
- 3.2. Интрапренёр нь журмын 2-р заалтыг хангасан интрапренёрийн хүсэлтийг харгалзан дараах дэмжлэг үзүүлнэ.
- 3.2.1. 1-р хагас жил - Интрапренёрийн цалинг хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу олгоно. Харин ажлын цагийн хувьд дараах байдлаар сонгон ажиллаж болно.
 - 3.2.1.1 Төслийг хөгжүүлэх, гүйцэтгэх хугацаа ажлын цагийн 20 хувиас хэтрэхгүй байх; Хөдөлмөрийн гэрээг үргэлжлүүлэн хийх
 - 3.2.1.2 Ажилтныг ажлын үндсэн чиг үүргээс 100 хувь чөлөөлж энэхүү журмын 1.5-д заасан хугацаанд үндсэн цалинг тогтмол олгож хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгоно.
 - 3.2.2 2-р хагас жил: Төсөл хэрэгжүүлж эхлэх үе шат, энэхүү шатанд өөрийн баг эсвэл дангаар ажил гүйцэтгэх бол дараах дэмжлэгүүдийн аль нэгийг үзүүлнэ. Үүнд:
 - Төслийн багийн 2-3 гишүүдийг хааб-д 6 сарын турш үнэ төлбөргүй суух, хурал, цуглаан, үйл ажиллагаа зохион байгуулах өрөө, танхимыг үнэгүй ашиглах нөхцөлөөр хангана (Хаабын ачааллаас шалтгаалж төслийн багийн гишүүдийн тоог нэмэгдүүлж болно)
 - 20 мкв хүртэлх өрөөг 1 жилийн хугацаанд, түрээсийн төлбөрөөс 50 хувийн хөнгөлттэй түрээслүүлнэ
 - Виртуал инкубаторт элсүүлж болно
 - Инкубаторт элсэх хүсэлт гаргасан тохиолдолд инкубаторын сонгон шалгаруулалтанд давуу талтай оролцоно
 - 3.2.3 МТҮП-с зохион байгуулж байгаа сургалт болон бусад ур чадвар нэмэгдүүлэх сургалт, семинар, арга хэмжээнд оролцоход дэмжлэг үзүүлнэ

ДӨРӨВ. ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 4.1. Дэмжлэг үзүүлэх эхний хагас жилийн хугацаанд үндсэн цалингаа авч буй үед гэрээгээр хүлээсэн үүрэг, ажлын байрны тодорхойлолт заасны дагуу дүрэм журмыг баримтлан ажиллана / Энэхүү заалт нь 2.3.3.1-т хамаарна/
- 4.2. Гадаад болон дотоодын төсөл хөтөлбөр, тендерүүдэд хамтарч ажиллах,
- 4.3. Мэдээлэл, технологийн үндэсний паркаас зохион байгуулж буй арга хэмжээнүүдэд, хамтарч ажиллах,
- 4.4. Нийгмийн хариуцлагын хүрээнд зохион байгуулж буй арга хэмжээнүүдэд паркын захирлын шийдвэрээр өрөө танхимыг үнэ төлбөргүй ашиглуулж болно
- 4.5. Бүтээгдэхүүн, үйлчилгээгээ паркад хөнгөлттэй нөхцөлөөр ашиглуулах;